

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2012 СУДАЛГААНЫ ДҮН

Агуулга

1. Судалгааны зорилго, товч үр дүн	4
2. Хүүхдийн шударга байдал-2012 судалгааны арга зүй, түүвэрлэлт	4
3. Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	5
4. Хүүхдийн шударга байдал 2012 судалгааны үр дүн	6
4.1 Судалгаанд оролцогчдын бүтэц	6
4.2 Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (2012 он).....	7
4.2 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ (2012 он)	11
4.4 Хүүхдийн зөв төлөвшлийн үнэлгээ (2012 он)	14
4.5 Хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахин биелүүлэх байдлын үнэлгээ (2012 он).	17
4.6 Авлигыг (үл) тэвчих байдлын үнэлгээ (2012 он).....	20
5. Дүгнэлт.....	23

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийг илэрхийлэх асуултуудын дугаар	4
Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ	9

Зургийн жагсаалт

Зураг 1: Хүүхдийн шударга байдал судалгааны үр дүн, (2008, 2010, 2012 он).....	4
Зураг 2: Хүүхдийн шударга байдал 2012 судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, байршлаар (дүнд эзлэх хувиар).....	6
Зураг 3: Судалгаанд оролцогчдын бүтэц (хүйсээр).....	6
Зураг 4: Судалгаанд оролцсон хүүхдүүдийн бүтэц (анги бүлгээр).....	7
Зураг 5: Хүүхдүүдийн шударга байдал 2008, 2010, 2012 оны үнэлгээ (байршлаар)	7
Зураг 6: Хүүхдүүдийн шударга байдлын 2008, 2010, 2012 оны үнэлгээ (хүйсээр).....	8
Зураг 7: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (насны ангилалаар).....	8
Зураг 8: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (суралцаж буй ангиар).....	9
Зураг 9. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ	11
Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар).....	11
Зураг 11. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр).....	12
Зураг 12. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлт (насны ангилалаар).....	12
Зураг 13. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)....	13
Зураг 14. Хүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ.....	14
Зураг 15. Хүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар).....	15
Зураг 16. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)	15
Зураг 17. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар).....	16
Зураг 18. Хүүхдийн төв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)	16
Зураг 19. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ ...	17
Зураг 20. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар).....	18


Зураг 21. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)	18
Зураг 22. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангиллаар)	18
Зураг 23. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)	19
Зураг 24. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ	20
Зураг 25. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)	20
Зураг 26. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)	21
Зураг 27. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)	21
Зураг 28. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)	22

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1. Судалгааны зорилго, товч үр дүн

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн дунд зан үйлийн зөв төлөвшил, ёс суртахуун ямар түвшинд байгааг судлах, цаашид шударга бус явдлын өмнө нугарахгүй зогсож чадах хүмүүсийг төлөвшүүлэхийн тулд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх ажлыг чиглүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршиж байгаа юм.

Хүүхдүүдийн шударга байдлын ерөнхий үнэлгээ 2.93 гарсан бөгөөд 2010 оны үнэлгээнээс 0.36 пунктээр буурсан байна (Зураг 1).



Зураг 1: Хүүхдийн шударга байдал судалгааны үр дүн, (2008, 2010, 2012 он)

2. Хүүхдийн шударга байдал-2012 судалгааны арга зүй, түүвэрлэлт

Судалгааг 2008 онд БНСУ-ын Транспарэнси интернэшнл байгууллагаас арваад орны эрдэмтэн судлаачдын боловсруулсан аргачлалын дагуу Энэтхэг, БНСУ, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан судалгааны асуулга, тооцоолох арга зүйг ашиглан явуулсан. Уг асуулга нь хүүхдүүдийн шударга байдал, ёс суртахууны төлөвшил, авлига болон гэмт хэргийг үл тэвчих байдал, аливаа асуудалд хандах хандлага, хууль, дүрэм, журам сахин биелүүлэх явдлыг хүүхдүүдээс маш энгийн, тэдэнд ойлгомжтой байдлаар асууж тодруулах боломж олгосноороо онцлог юм.

Хүснэгт 1: Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийг илэрхийлэх асуултуудын дугаар

	Ёс зүй / Ёс суртахуун	Зөв төлөвшил	Хууль ягштал сахих	Авлигыг /үл/ тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

Хүүхдийн шударга байдлын түвшинг Хүснэгт 1-д байгаа асуулт – дэд үзүүлэлтээр тодорхойлж гаргаж ирсэн. Асуултуудаар илэрхийлсэн үзэл санаатай хүүхдүүдийн үзэл бодол нийлж байгаа эсэхийг “Санал бүрэн нийлж байна” гэдгээс эхлэн “Санал огт нийлэхгүй байна” хүртэл үнэлгээ хийлгэсэн. Шударга байдлын түвшингийн үзүүлэлт нь 1-10 гэсэн утгаар илэрхийлэх ба 10 руу ойртох тусам маш сайн, 1 рүү ойртох тусам маш муу гэсэн утгыг

илэрхийлнэ. Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох мэдээллийн эх үүсвэр нь “Хүүхдийн шударга байдал 2012” судалгааны үр дүн байв.

7-11 дүгээр ангид суралцаж буй хүүхдийн тоогоор аймгуудыг бүлэглэж, бүлэг тус бүрээс нэг аймгийг санамсаргүй байдлаар сонгосон. “Хүүхдийн шударга байдал 2012 судалгаа”-нд Дорноговь, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Хөвсгөл аймаг, Нийслэлийн Чингэлтэй, Сонгино-Хайрхан, Налайх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 851 сурагчдыг хамруулсан.

3. Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт


Судалгааны ажлыг АТГ-ын Судалгаа шинжилгээний алба зохион байгуулж явуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газартай хамтран 2012 оны 03 дугаар сарын 09-аас 15-ны хооронд хийсэн юм.

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CPro 4.0 (Census and Survey Program) программ дээр боловсруулсан. Мэдээллийг оруулж дууссаны дараа CPro 4.0 программын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) программ руу хөрвүүлсэн. SPSS 16.0, EXSEL программыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайлан бэлтгэхэд ашигласан.

4. Хүүхдийн шударга байдал 2012 судалгааны үр дүн


4.1 Судалгаанд оролцогчдын бүтэц

Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцогчдыг байршлаар нь авч үзвэл 36.8 хувь нь нийслэлийн, 63.2 хувь нь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байлаа (Зураг 2).



Зураг 2: Хүүхдийн шударга байдал 2012 судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, байршлаар (дүнд эзлэх хувиар)

Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцогчдын бүтцийг хүйсээр авч үзвэл 45.4 хувийг эрэгтэй сурагчид, 54.6 хувийг эмэгтэй сурагчид эзэлж байна. (Зураг 3).




Зураг 3: Судалгаанд оролцогчдын бүтэц (хүйсээр)

Судалгаанд оролцсон хүүхдүүдийг насны бүтцээр авч үзвэл 11 настай сурагчид 0.1 хувийг, 12 настай сурагчид 2.0 хувийг, 13 настай сурагчид 8.5 хувийг, 14 настай сурагчид 20.4 хувийг, 15 настай сурагчид 25.2 хувийг, 16 настай сурагчид 19.4 хувийг, 17 настай сурагчид 16.6 хувийг, 18 настай сурагчид 1.2 хувийг тус тус хүүхдүүд эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын бүтцийг сурч байгаа ангиар авч үзвэл 14.92 хувь нь 7 дугаар ангид, 30.08 хувь нь 8 дугаар ангид, 18.33 хувь нь 9 дүгээр ангид, 19.86 хувь нь 10 дугаар ангид, 16.8 хувь нь 11 дүгээр ангид тус тус суралцаж байна (Зураг 4).


Зураг 4: Судалгаанд оролцсон хүүхдүүдийн бүтэц (анги бүлгээр)



4.2 Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (2012 он)


Хүүхдийн шударга байдлын үнэлгээг 2010 оныхтой харьцуулбал нийслэлд оршин суудаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 0.23, орон нутагт оршин суудаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 0.33-аар тус тус буурсан байна. (хүснэгт 5)

Зураг 5: Хүүхдүүдийн шударга байдал 2008, 2010, 2012 оны үнэлгээ (байршлаар)




Хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээг хүйсээр үзвэл эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ эмэгтэй хүүхдийнхээс 0.29 пунктээр илүү байна (Зураг 6). Уг үзүүлэлтийг 2010 оны дүнтэй харьцуулбал эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 0.35, эмэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 0.39-аар тус тус буурсан байна. 2010 судалгааны дүнгээр эмэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ эрэгтэй хүүхдийнхээс бага байсан бол энэ удаагийн судалгаагаар мөн давтагджээ.

Зураг 6: Хүүхдүүдийн шударга байдлын 2008, 2010, 2012 оны үнэлгээ (хүйсээр)




Хүүхдийн шударга байдлын үнэлгээг хүүхдийн насны ангиллаар авч үзвэл, 16 насныхны шударга байдлын үнэлгээ (3.20) бусад насныхнаас өндөр гарчээ (Зураг 7).

Зураг 7: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (насны ангилалаар)



Хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл 10 дугаар ангийн сурагчдын шударга байдлын үнэлгээ (3.3) харьцангуй өндөр гарсан байна (Зураг 8).

Зураг 8: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (суралцаж буй ангиар)



Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийн үзүүлэлтүүдийн үнэлгээг Хүснэгт 2-д харуулав. Хууль биелүүлэх зан үйлийн үзүүлэлт (-0,82), Хууль биелүүлэх танин мэдэхүйн дэд үзүүлэлт (-0.81), Хүүхдийн ёс суртахууны талаарх танин мэдэхүйн дэд үзүүлэлт (-0.48), Авлигыг үл тэвчих нөлөөллийн дэд үзүүлэлт (-0,48)-үүд нь бусад үзүүлэлтээс илүү нэмэгдсэн.

Хүүхдүүдийн зөв төлөвшлийн танин мэдэхүй (1.85) болон нөлөөллийн дэд үзүүлэлт (1.94), хууль ягштал биелүүлэх зан үйлийн дэд үзүүлэлт (1.98)-ийн үнэлгээ харьцангуй доогуур гарсан. Авлигыг үл тэвчих нөлөөллийн дэд үзүүлэлт (6.23)-ийн үнэлгээ харьцангуй сайн гарсан.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

Д/д			Дэд үзүүлэлт	Үнэлгээ	
				2010	2012
1	Ёс суртахуун	Танин мэдэхүй	Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн зүйлийг хуулчихаад багшдаа би бичсэн гэж хэлэх нь буруу зүйл биш	3.2	2.72
2	Ёс суртахуун	Нөлөөлөл	Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл	2.7	2.49
3	Ёс суртахуун	Зан үйлийн	Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ	3.2	2.99
			Бүлгийн дундаж	3.03	2.73
1	Зөв төлөвшил	Танин мэдэхүй	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш	2.2	1.85
2	Зөв төлөвшил	Нөлөөлөл	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга	2.2	1.94
3	Зөв төлөвшил	Зан үйлийн	Авлига авсан, хулгай хийсэн, хүн зодсон гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь хэлнэ.	3.1	3.10
			Бүлгийн дундаж	2.51	2.29


1	Хууль ягштал сахих	Танин мэдэхүй	Миний сайн найз шалгалтан дээрээ хуулж болно. Энэ буруу зүйл биш	4.42	3.61
2	Хууль ягштал сахих	Нөлөөлөл	Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно	3.4	2.96
3	Хууль ягштал сахих	Зан үйлийн	Ойр хавьд цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм зөрчиж болно.	2.8	1.98
			Бүлгийн дундаж	3.54	2.85
1	Авлигыг үл тэвчих	Танин мэдэхүй	Миний амьдралд сайнаар нөлөөлж байвал томчууд хууль зөрчиж болно. Энэ бол буруу зүйл биш	2.7	2.34
2	Авлигыг үл тэвчих	Нөлөөлөл	Шалгалтандаа хуулсан л бол сайн найз байсан ч энэ тухай би багш, эцэг, эх, ах эгчдээ хэлнэ.	6.71	6.23
3	Авлигыг үл тэвчих	Зан үйлийн	Манай аав ээж, ах эгч төрийн байгууллагад ажилладаг. Тэд албан тушаалаа ашиглан баян болох нь буруу зүйл биш	2.9	2.97
			Бүлгийн дундаж	4.1	3.84

4.2 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээг ёс суртахууны талаарх ойлголт, ёс зүй, суртахуунд нөлөөлөх нөлөөлөл, одоо тус дэд үзүүлэлт ямар түвшинд байгааг дараах гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.


- Ёс суртахууны талаарх танин мэдэхүйг нь - Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
- Ёс суртахуунд нөлөөлөх нөлөөллийг - Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл.
- Ёс суртахууны зан үйл нь - Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.

Хүүхдүүдийн өнөөдрийн ёс суртахууны төлөв байдал, ёс зүйн байдлын хэм хэмжээ, стандарт ямар байгаад үнэлгээ өгч байгаа тус бүлгийн дундаж үнэлгээ 2.73 байна. 2010 оны судалгаатай харьцуулахад 0.3 хувиар буурсан. (Зураг 9)




Зураг 9. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ

Нийслэлийн хүүхдүүд (2.84) орон нутагт оршин суудаг хүүхдүүдээс (2.59) ёс зүйн, ёс суртахуун 0.25 пунктээр, эрэгтэй хүүхдүүд (2.99) эмэгтэй хүүхдүүдээс (2.52) 0.47 пунктээр тус тус өндөртэй байна (Зураг 10, 11).




Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)



Зураг 11. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)


Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ 11 наснаас (1.50) бага багаар дээшилсээр 18 насанд (3.34) болжээ. (хүснэгт 12)

Зураг 12. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлт (насны ангилалаар)



Хүүхдүүдийн ёс зүйн хэм хэмжээ ямар байгааг харуулж буй тус дэд үзүүлэлтийн үнэлгээг хүүхдүүдийн сурч буй ангиар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: Хамгийн доогуур үнэлгээ 8 ба 9 ангид (2.35, 2.22), хамгийн дээд үнэлгээ 10 ангид (2.97) байж байгаад 11 дүгээр ангид доошилж 2.74 болжээ. (хүснэгт 13)

Зураг 13. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)




4.4 Хүүхдийн зөв төлөвшлийн үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн зөв төлөвшлийн үнэлгээг хүүхдүүдийн зөв бурууг ялгах байдал, нөлөөлөх нөлөөлөл, хэрхэн илэрч байгааг дараах гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Зөв төлөвшлийг танин мэдэхүй нь - Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
- Зөв төлөвшилд нөлөөлөх нөлөөллийг - Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга.
- Зөв төлөвшлийн илэрч буй зан үйл нь - Авлига авсан, хулгай хийсэн, хүн зодсон гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь хэлнэ.



Хүүхдүүдийн зөв бурууг ялгаж салган ойлгох чадвар ямар байгаад үнэлгээ өгч байгаа тус бүлгийн дундаж үнэлгээ 2.3 байна. (Зураг 14) Энэ нь хүүхдүүдийн ёс суртахуун, буруу зөв сайн мууг ойлгох чадвар, нийгмээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг дагаж мөрдөх чадвар, авлигыг үл тэвчих гэсэн дэд үзүүлэлтүүд дотор хамгийн доод үнэлгээ бөгөөд хүүхдүүд өнөөдөр сайн муу, буруу зөвийг ялгах чадвар харьцангуй муу байгааг харуулж байна.



Зураг 14. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ

Нийслэлд оршин сууж буй хүүхдүүд (2.43) орон нутагт оршин сууж буй хүүхдүүдээс 0.23 пунктээр илүүтэйгээр зөв бурууг ялган ойлгох чадварын үнэлгээ өндөр байна (Зураг 15). Зөв бурууг ялгах чадварын үнэлгээ эрэгтэй хүүхдүүд (2.36) охидоос (2.24) 0.12 пунктээр илүү гарчээ (Зураг 16).


Зураг 15. Хүүхийн зөв төлөшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)



Зураг 16. Хүүхийн зөв төлөшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)


Одоогийн хүүхдүүдийн зөв буруу, сайн мууг ялгаж салгаж ойлгох чадварыг хүүхдүүдийн насны хувьд авч үзвэл хамгийн дээд үнэлгээ 12 насныхан 2.49 байгаад доошилсоор 14 настай 2.14 болж буураад, 18 насанд 2.45 болж өссөн байна. (Зураг 17).

Зураг 17. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)



Суралцаж буй ангиар нь авч үзвэл 8 дугаар ангид (2.01) байснаа 10, 11 дүгээр ангид 2.42 болж өссөн байна. (Зураг 18).

Зураг 18. Хүүхдийн төв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)




4.5 Хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахин биелүүлэх байдлын үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн нийгмээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахин биелүүлэхэд өөрсдийгөө хэрхэн хянах чадвартайг харуулж буй дэд үзүүлэлтийг хэрхэн илэрч байгааг дараах гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Хууль ягштал сахих явдлыг танин мэдэхүй нь - Миний сайн найз шалгалтан дээрээ хуулж болно. Энэ буруу зүйл биш.
- Хууль ягштал сахих явдалд нөлөөлөх нөлөөллийг - Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно.
- Хууль ягштал сахих явдал илэрч буй зан үйл нь - Ойр хавьд цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм зөрчиж болно.


Өсвөр насныхны ихэвчлэн зан байдал төлөвшөөгүй байдаг ба олон нийтээр хүлээн зөвшөөрөн дагаж мөрдөж буй хууль, дүрэм, журмыг хүндэтгэн дагах явдлыг төлөвшүүлэх нь чухал асуудал юм. Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгааны үр дүнгээр энэхүү хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хүүхдүүд дагаж мөрдөх, өөрсдийгөө хянах чадварыг илтгэх тус дэд үзүүлэлтийн бүлгийн дундаж үнэлгээ 2.85 байна. (Зураг 19) Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаатай харьцуулахад хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахих үнэлгээ бусад дэд үзүүлэлтүүдийн үнэлгээнээс хамгийн их хувиар буюу 0.68%-аар буурчээ.




Зураг 19. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ

Нийслэлд оршин сууж буй хүүхдүүд (3.11) орон нутагт амьдарч байгаа хүүхдүүдээс (2.65) 0.46 пунктээр хууль сахих чадвар өндөр байна. (Зураг 20)

Эрэгтэй хүүхдүүд (3.40) охидоос (2.73) 0.67 пунктээр илүү хууль, дүрэм, журам сахих чадвартай байна (Зураг 21).




Зураг 20.
Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)



Зураг 21.
Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)


Хүүхдүүдийн насны хувьд тус дэд үзүүлэлтийг аваад үзвэл хамгийн доод үнэлгээ 13, 14 настай (2.66), хамгийн дээд үнэлгээ 15, 16 насанд буюу 3.05 тус тус байна. (хүснэгт 22)

Зураг 22. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангиллаар)



Тус дэд үзүүлэлтийн үнэлгээг хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: 7 дугаар ангиас (2.79) буурч 10 ангид (3.30) болж өсөөд 11 ангид 2.84 болж 0.46 пунктээр буурсан байна. (хүснэгт 23)

Зураг 23. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)




4.6 Авлигыг (үл) тэвчих байдлын үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих чадварыг хэмжих дэд үзүүлэлтийг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.


- Авлигыг үл тэвчих явдлыг танин мэдэхүй нь - Миний амьдралд сайнаар нөлөөлж байвал томчууд хууль зөрчиж болно. Энэ бол буруу зүйл биш.
- Авлигыг үл тэвчих явдалд нөлөөлөх нөлөөллийг - Шалгалтандаа хуулсан л бол сайн найз байсан ч энэ тухай би багш, эцэг, эх, ах эгчдээ хэлнэ..
- Авлигыг үл тэвчих явдлын илэрч буй зан үйл нь - Манай аав ээж, ах эгч төрийн байгууллагад ажилладаг. Тэд албан тушаалаа ашиглан баян болох нь буруу зүйл биш

Хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих явдлыг илэрхийлэх дэд үзүүлэлийн бүлгийн дундаж үнэлгээ 3.85 гарсан. (Зураг 24) Хүүхдүүдийн авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ бусад дэд үзүүлэлтүүдийн үнэлгээнээс хамгийн их хувиар буюу 0.68%-аар буурсан. Гэвч хүүхдийн суртахуун, зөв төлөвшил, хууль ягштал сахих дэд үзүүлэлтээс өндөр байна.




Зураг 24. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ

Нийслэлд оршин суудаг хүүхдүүд (4.21) орон нутаг оршин суудаг хүүхдүүдээс (3.60) илүүтэйгээр авлигыг үл тэвчих явдал 0.61 пунктээр өндөр байна. (Зураг 25) Хүүхдүүдийн аливаа гэмт хэрэг шударга бус явдлыг үл тэвчих явдалд эрэгтэй хүүхдүүд (4.0) охидоос (3.72) 0.28 пунктээр өндөр чадвартай байна (Зураг 26).




Зураг 25. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)



Зураг 26. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)


Хүүхдүүдийн авлигыг үл тэвчих чадварыг насны хувьд авч үзвэл 11 наснаас (3.11) бага багаар 17 нас хүртэл (4.31) тогтворгүй өсч байгаад 18 насанд 3.90 болж буурчээ. (Зураг 27).

Зураг 27. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)



Тус дэд үзүүлэлтийг хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл анги ахих тутам хүүхдүүд аливаа гэмт хэргийг үл тэвчих чадвар дээшилж байна (Зураг 28).

Зураг 28. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)



5. Дүгнэлт

“Ирээдүйд бид авлигатай амжилттай тэмцэхийн тулд өнөөдөр урьдчилан сэргийлэх хэрэгтэй, шударга ёсны хүмүүжил бол ёс зүйн маш нарийн эмзэг асуудал” гэж анхлан санаачлагч Транспаренси-Кореа байгууллага үзэж энэхүү судалгааны ажлыг эхлүүлсэн.

Хүүхдүүдийн шударга байдлын түвшингийн ерөнхий үнэлгээ 2.93 гарсан бөгөөд 2010 оны үнэлгээнээс 0.36 пунктээр буурсан байна. Бүх дэд үзүүлэлтийн үнэлгээ буурсан, орон нутагт оршин сууж буй хүүхдүүдийн ёс суртахууны байдал, зөв бурууг ойлгох явдал, хууль, дүрэм журам сахин биелүүлэх чадвар, авлигыг үл тэвчих зэрэгт нийслэлд оршин сууж буй хүүхдүүдээс, түүнчлэн охид хөвгүүдээс тус тус доогуур гарлаа.

Өнөөгийн хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээ, ёс суртахууны талаархи ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, стандарт, сайн муу буруу зөвийг ялгаж салгаж ойлгох чадвар, нийгмээр хүлээн зөвшөөрөн сахиж биелүүлэх хууль дүрэм журмыг сахин биелүүлэх хүүхдүүдийн чадвар, авлигыг үл тэвчих зэрэг дэд үзүүлэлтээс хүүхдүүд сайн муу, буруу зөвийг ялгах чадвар хамгийн доогуур үнэлгээтэй байна. Авлигын гэмт хэргийг үл тэвчих дэд үзүүлэлтийн үнэлгээ бусад дэд үзүүлэлтийн үнэлгээтэй харьцуулахад хамгийн өндөр байлаа.